

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2017 оны 01 дүгээр  
сарын ~~1~~ний өдөр

Дугаар ~~А/16.1~~ ~~А/30~~

Улаанбаатар  
хот

Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний  
хүртээмжийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1, 8.1.5 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 60, 61 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, Батлан хамгаалахын сайд, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/371, А/207 дугаар хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Цэргийн төв эмнэлгийн “Хүүхдийн тасаг”-т Баянзүрх дүүргийн 8, 10, 13, 16, 17 дугаар хороо; Чингэлтэй дүүргийн 9, 10, 13 дугаар хорооны хүүхдийн тусламж, үйлчилгээг үзүүлэхээр хуваарилсугай.

2. Цэргийн төв эмнэлгийн “Хүүхдийн тасаг”-ийг ажиллуулахад нэн тэргүүнд шаардагдах эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлын тооцоог гаргаж, Засгийн газраар шийдвэрлүүлэхийг хамтарсан Ажлын хэсгийн дарга нар /бригадын генерал Г.Сайханбаяр, Д.Төмөртоогоо/-т тус тус даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/-д, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д тус тус даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалах яам болон Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар /хурандаа Х.Батбилэг, Д.Очирбат /-т тус тус үүрэг болгосугай.

